



**ЭНЭБИШИЙН БАЯРМАА**

Монгол улсын их сургууль, Монгол улсын боловсролын их сургууль, Солонгос улсын Хансэй их сургууль, Нийгэм сэтгэл судлалын дээд сургуульд суралцаж сэтгүүлч, орчуулагч, сэтгэл судлаач мэргэжил эзэмшсэн. Магистр зэрэгтэй. Олон улсын сэтгэц заслын институтын (IPI) “Сэтгэл зүйн зөвлөгөө, засал” цуврал сургалтыг онлайнаар дүүргэсэн.

Нийгэм, сэтгэл судлалын дээд сургуулийн багш, сэтгэл зүйч. Байгууллагын сэтгэл зүйн захиалгат сургалтын сургагч багш. Хувь хүний хөгжил, сэтгэл зүйн салбарт дараах номыг бүтээж уншигчдын хүртээл болгосон.

“Амжилтын төлөвлөгөө”, “Ухаалаг сонголт”, “Мэргэжил сонголт таны амьдралыг шийднэ”, “Нийтлэг тохиох өвчний сэтгэл зүйн шалтгаан”, “Хайр”, “Анзаарч чадвал амьдрал сайхан, “Толины хууль” зэрэг номыг англи болон солонгос хэлнээс орчуулж хэвлүүлсэн.

Өөрийн ажлын туршлагаасаа үндэслэн “Одоо цагт амьдрах урлаг”, “Сэтгэл хөдлөлөө жолоодох урлаг”, “Хүсэл мөрөөдөлдөө хүрэх дөт зам”, “Салалтын дараах сэтгэл зүйн тусламж”, “Өөртөө итгэлтэй болох сэтгэл зүйн нууц аргууд” зэрэг номыг бичиж Монголын болон Өвөр монголын уншигчдад хүргээд байна.

## Э.БАЯРМААГИЙН БҮТЭЭЛ

